

Зураг төслийн баримт бичгийн

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

“Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын Цогцэций өртөөн дэх Зэхэлтийн депогийн замын ажлын зураг төсөл”

Зураг төслийн бүрдэл:

1. Зэхэлтийн депогийн замуудын зураг төсөл

a/ Дэвсгэр /план/ зураг-4 хуудас, дагуу аясын зураг -10 хуудас, замуудын хөндлөн огтлолын зураг-52 хуудас

2021 оны 04 сарын 08 өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр	“Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын Цогцэций өртөөн дэх Зэхэлтийн депогийн замын ажлын зураг төсөл”
2	Объектын байршил, хүчин чадал	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын Цогцэций өртөө, Зэхэлтийн депогийн замууд
3	Зураг төслийн байгууллага	“Монголын төмөр зам” ТӨХК
3. Дүгнэлтийн төвч утга: /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалын 9 дүгээр зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсэн байдал;	1. Зэхэлтийн депогийн байршлыг нь Цогцэций өртөөний хүлээн авах явуулах замууд, ачааны зонхилох урсгалын чиглэлээс хамааран сонгосон 2. Депогийн замуудын ерөнхий схем зургийг УБТЗ-ын Зүтгүүрийн аж ахуйн албаны удирдлага, инженерүүдийн оролцоотойгоор хэлэлцэн гаргасан нь оновчтой болсон
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	1. Зэхэлтийн депогийн замуудын зориулалт, тоо хэмжээ, харилцан байршил, инженерийн шийдэл, бүтэц нь “1520мм царигтай төмөр зам Техникийн ерөнхий шаардлага MNS 6229 : 2010” стандарт, Зэхэлтийн депогийн техникийн нөхцөл, бусад норм дүрмийн шаардлагыг бүрнээ хангахуйцаар зохиогдсон
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх	Замын чигийн байршлын сонголт, дагуу аясын төлөвлөлтийг чигийн хувилбаруудаас хийсэн сонголт нь төмөр замын норм, дүрэм, стандарт, байгаль

	дүгнэлт;	орчинг хамгаалах шаардлагыг бүрнээ хангаж байгаа болно
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Замуудын байршил, доод дээд бүтэц, дагуу ба хөндлөн огтлолын зургуд нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны норм дүрмийн шаардлагыг хангаж байна.
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлэс/	
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	Боломжийн. Депогийн салбар замуудыг Цогцэций өртөөний хүлээн авах, явуулах замууд, бусад замуутай зохистой уялдуулж төсөллөсөн
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	Энд тийм байгууламж байхгүй
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Стандарт, норм, дүрмийн дагуу оновчтой төлөвлөсөн
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	Шинэ замын дээд доод бүтээц, барилга байгууламжийн угсралтын зураг тул тийм тусгайлсан төлөвлөлт шаардлагагүй
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар төвч, тодорхой тусгана.	ДҮГНЭЛТ: Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын Цогцэций өртөөний Зэхэлтийн депогийн салбар замуудын зураг төсөл нь Монгол улсад эдүгээ мөрдөж байгаа 1520мм-ийн царигтай төмөр замын стандарт, норм, дүрмийн шаардлага, зэхэлтийн депогийн үйлчилгээний үндсэн үйл ажиллагааг бүрнээ хангахуйцаар зохиогдож, Тавантолгойн нүүрсний дотоодын тээвэр, экспортыг нэмэгдүүлж, улсын эдийн засгийн ёсөлтийг хангах чухал ач холбогдолтой учир Цогцэций өртөөний Зэхэлтийн депогийн эдгээр замуудыг барих зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.